

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2023 оны 06 дугаар сарын 15-ны өдөр, Пүрэв гараг**

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-3

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 4-9

1.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд нарын 4 гишүүн 2023.04.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн дагуу/ 4-9

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы
Төрийн байгуулалтын байнгын хорооны
06 дугаар сарын 15-ны өдөр /Пүрэв гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Н.Энхболд ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 15 цаг 33 минутад Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд эхлэв.

Томилолттой: С.Бямбацогт;

Чөлөөтэй: Ё.Баатарбилэг, Л.Оюун-Эрдэнэ, Х.Нямбаатар;

Эмнэлгийн чөлөөтэй: Ц.Мөнхцэцэг.

Нэг.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд нарын 4 гишүүн 2023.04.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн дагуу/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Баянмөнх, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан референт Э.Баттогтох нар байлцав.

Н.Энхболд: Байнгын хорооны 2023 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төслийн талаарх 10 дахь зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг Байнгын хорооны эцсийн хэлэлцүүлгээр дахин хэлэлцэж, томьёолох шаардлагатай тул уг асуудлыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн дагуу хэлэлцэж, саналаа нэгдсэн хуралдаанд оруулахыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 0
Бүгд: 10
100 хувийн саналаар дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн дагуу уг асуудлыг хэлэлцэх хуралдааны дэгийг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар батлах тул хуралдаан 15 цаг 38 минутаас 16 цаг 32 минутад тур завсарлав.

Н.Энхболд: Байнгын хорооны 2023 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн хуралдаанаар санал хураалгаж, дэмжигдсэн 10 дугаар санал буюу Төслийн 4 дүгээр зүйлийн “30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсгийн” гэсний дараах ““20-оос” гэснийг “40-өөс” гэж” гэснийг ““20-оос” гэснийг “30-аас” гэж” гэж өөрчлөх гэсэн саналыг хүчингүй болгох санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 0
Бүгд: 14

100 хувийн саналаар дэмжигдлээ.

Н.Энхболд: Төслийн 4 дүгээр зүйлийн ““20-оос” гэснийг “40-өөс” гэж” гэснийг “нэр дэвшиж байгаа нийт нэр дэвшигчийн 20-оос доошгүй” гэснийг “нэр дэвшүүлэхэд 2024 оны ээлжит сонгуулиар нийт дэвшигчийн 30-аас доошгүй хувь нь, 2028 оны ээлжит сонгуулиар 40-өөс доошгүй” гэж” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Т.Доржханд үг хэлэв.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 1
Бүгд: 14
92.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Н.Энхболд: Төслийн 1 дүгээр зүйлийн 30 дахь заалт буюу 53 дугаар зүйлийн 53.4 дэх хэсгийн “дээд хэмжээнээс” гэснийг “хэмжээний дунджаас” гэж өөрчлөх гэсэн саналыг хураалгахыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн үг хэлэв.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 1
Бүгд: 14
92.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Н.Энхболд: Байнгын хорооны 2023 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн хуралдаанаар санал хураалгаж, дэмжигдсэн “43.2-т заасан жагсаалтаар нэр дэвшигч нам, эвслийн сонгуулийн сурталчилгаанд зориулан хандив өгч болох бөгөөд нэг нэр дэвшигчийн өгсөн хандивын хэмжээ нь энэ хуульд заасны дагуу тогтоосон нэр дэвшигчээс тойрогт зарцуулах зардлын дээд хэмжээнээс хэтрэхгүй байна.” гэсэн саналыг хүчингүй болгох санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 0
Бүгд: 14
100 хувийн саналаар дэмжигдлээ.

Н.Энхболд: Төслийн 1 дүгээр зүйлийн 30 дахь заалт буюу 53 дугаар зүйлийн 53.4 дэх хэсгийн “дээд хэмжээнээс” гэснийг “хэмжээний дунджаас” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 0
Бүгд: 14
100 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Ж.Батсуурь, Ц.Мөнх-Оргил нар үг хэлэв.

Уг асуудлыг 16 цаг 53 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 26 минут үргэлжилж, ирвэл зохих 19 гишүүнээс 14 гишүүн хүрэлцэн ирж, 73.7 хувийн ирцтэйгээр 16 цаг 53 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Н.ЭНХБОЛД

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 06 дугаар сарын 15-ны өдөр,
Пүрэв гараг
Төрийн ордон “Үндсэн хууль” танхим
15 цаг 33 минут.

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Н.Энхболд: Байнгын хорооны гишүүдийнхээ энэ өдрийн амрыг эрвэ. Байнгын хорооны хуралдаанд Ганболд гишүүн, Сүхбаатар гишүүн, Доржханд гишүүн, Оюунчимэг гишүүн, Тогтохсүрэн гишүүн, Энхболд гишүүн, Занданшатар гишүүн, Батсуурь гишүүн, Мөнх-Оргил гишүүн, Сарангэрэл гишүүн ирж, нийт 10 хүн ирсэн учраас хуралдааны ирц бүрдсэн байна. Хуралдаанаа нээе.

Нөхцөл байдалтай уялдуулаад нэг ийм асуудал гараад байгааг би танилцуулъя. Өчигдөр бид нар Байнгын хорооны хуралдаанаа хийгээд, Сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг Байнгын хороогоороо хийчихсэн байгаа. Эцсийн хэлэлцүүлэг хийсний дараа чуулганы нэгдсэн эцсийн хуралдаанаар хэлэлцэхийн өмнө дахиад бас тодорхой асуудлуудаар санал солилцох, цөөнхийн, эмэгтэйчүүдийн лоббигийн бүлгийн зүгээс бусад мөн иргэд, байгууллага, нийгмийн зүгээс бас тодорхой саналууд ирсэнтэй холбогдуулаад бид нар өчигдөр эцсийн хэлэлцүүлгээр хэлэлцэж, Байнгын хороогоор бол дэмжчихсэн нэг саналаа эргээж ярих шаардлага гарч байгаа юм.

Ингээж эргээж ярих шаардлага байгаа учраас эцсийн хэлэлцүүлгээ нэгэнт санал хураагаад өнгөрчихсөн болохоор хуралдааны дэгээ яах вэ гэдэг асуудал гарч ирсэн. Ингээд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5.1 дүгээр зүйлд хуралдааны дэгээр зохицуулаагүй асуудлыг хэлэлцэх журам 5.1.Тухайн асуудлыг хэлэлцэх

хуралдааны дэгийг хуулиар зохицуулаагүй бол уг асуудлыг хэлэлцэх дэгийг Төрийн байгуулалтын байнгын хороо хэлэлцэж, саналаа нэгдсэн хуралдаанд оруулна. 5.2.Төрийн байгуулалтын байнгын хорооноос санал болгосон тухайн асуудлыг хэлэлцэх хуралдааны дэгийг нэгдсэн хуралдаанд оролцсон Их Хурлын гишүүдийн олонхын саналаар батална гэсэн ийм зохицуулалт байгаа.

Мөн 5.3-д нь энэ хуулийн 5.1-д заасан хуралдааны дэгийг зөвхөн тухайн асуудлыг хэлэлцэн шийдвэрлэхэд мөрдөнө гэсэн ийм 3 заалттай, 5 дугаар зүйлийн зохицуулалт байна. Энэний дагуу одоо хэдүүлээ энэ удаагийн хуралдаанаар өнгөрсөн эцсийн хэлэлцүүлгээр хуралдаад дэмжчихсэн байгаа саналууд дотроос буюу өнөөдөр Улсын Их Хуралд хураалгахаар зарчмын зөрүүтэй санал болгож ирсэн жагсаалтад байгаа 10 дахь саналыг дахин хэлэлцэх дэгээ Их Хурлаараа батлуулж авах хэрэгтэй байна. 10 дугаар санал маань бол төслийн 4 дүгээр зүйлийн, 30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсгийг гэсний дараах 20-иос гэснийг 40-өөс гэж гэснийг 20-иос гэснийг 30-аас гэж өөрчилье гэсэн ийм санал байсан. Энийг Байнгын хороо дэмжчихсэн байгаа. Тэгэхдээ энийг дахиж ярих ийм шаардлага гарч байгаа учраас дэгээ юуны өмнө чуулганы нэгдсэн хуралдаанд оруулаад хэдүүлээ батлаад авъя.

Тэгээд хэрэв чуулганы нэгдсэн хуралдаанаар бидний санал Байнгын хорооноос санал болгож байгаа дэгийг, нэг удаа хэрэглэх дэгийг батлаад өгвөл эргээж орж ирээд хэдүүлээ саналаа ерөнхийд нь томъёолоод байж байгаа. Ойлголцсон, ярилцсан хүрээндээ. Тэгээд тэр саналаараа дахиж томъёолол 2/3-роороо босгож, босгож байгаад түрүүчийнхээ саналыг хүчингүй болгоод, дараагийнхаа саналыг 2/3-роороо хураах дэгээ дахиж дотроо батлаад, дахиад шинээр томъёолсон томъёоллоо хуулийнхаа заалтыг батлаад, тэгээд чуулганы нэгдсэн хуралдаанд 2-т дахиад оруулах ийм дарааллаар өнөөдрийн ажил явна.

Тэгэхээр би одоо 5 дугаар, Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан 5.1. тухайн асуудлыг хэлэлцэх хугацааны хуралдааны дэгийг хуулиар зохицуулаагүй бол уг асуудлыг хэлэлцэх дэгийг Төрийн байгуулалтын байнгын хороо хэлэлцэж, саналаа нэгдсэн хуралдаанд оруулна гэсний дагуу саяын жагсаалтад байгаа 10 дахь заалтыг дахин нэг хэлэлцье гэсэн дэгийн санал гаргаж, санал хураалгах гэж байна. Ойлгомжтой юу тийм ээ? Тэгвэл саналаа саяын миний томъёолсноор хураагаад, Байнгын хорооны гишүүдийн олонх дэмжвэл ороод дэгээ батлуулчихаад, тэгээд эргэж орж ирээд томъёоллоо дахиж ярья.

Санал хураалт явуулъя. 10-аас 10, 100 хувийн саналаар дэмжлээ. Тэгэхээр одоо манай Тамгын газрынхан яг Байнгын хорооноос Их Хурал нэгдсэн хуралдаанд оруулах дэгийг яг юу гэж томъёолоод оруулах вэ гэдгээ эцэслэж, нэг харчхаад, надаа өгөхөд бэлдээд байж байгаарай.

Хуралдаанаа түр завсарлая. Чуулганы эцсийн хуралдаанд асуудлаа, дэгийнхээ асуудлыг оруулчихаад эргэж цуглаад саналаа хураана. Чуулгандаа оригооё хэдүүлээ. Тэр хооронд бид нар юу саналаа томъёолчихоод, хураалгаад. 2 зүйл ярихаар боллоо шүү. Эхлээд одоо оруулах юмнуудаа хураалгаадах тийм ээ. Тэгээд дараа нь яах вэ бид нар эндээ орж ирж байгаад ийм л томъёолол гарах ёстой.

Хуралдаан 15 цаг 38 минутаас 16 цаг 32 минутад түр засварлав.

Хуралдаанаа үргэлжлүүлъя гишүүдээ, гишүүдээ. Бид нар сая Их чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар бүлгийн заалтын дагуу чуулганы нэгдсэн хуралдаанд асуудал оруулаад, Байнгын хороогоор эцсийн хэлэлцүүлгээр хэлэлцсэн 2 асуудлаа эргээд хэлэлцэх тодотгох ийм боломжийг нээсэн дэг зөвшөөрүүлсэн. Тэгээд энэний дагуу 2, 3 санал хураалт явуулна.

1 дүгээрт хүйсийн квоттой холбоотой санал байгаа. Ер нь бол төслөөрөө нэг хүйсийн төлөөлөл нэр дэвшигчийн 20-оос доошгүй хувь байна гэсэн заалтыг өөрчлөөд 30-аас доошгүй болгож бид нар төсөлдөө тусгасан. Хэлэлцүүлгийн явцад Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаан дээр энэ асуудлыг хэлэлцэх үеэр Байнгын хороогоор хэлэлцэх үеэр чуулганы хуралдааны хэлэлцэх үеэр 20-иос доошгүй гэснийг 40-өөс доошгүй гэж болгож өөрчилсөн байсан. Эргээд Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх үед 40-өөс доошгүй гэж байсныг 30-аас доошгүй гэж, 30-аас доошгүй гэж байсныг 40-өөс доошгүй гэж болгож өөрчилсөн. Энэний дагуу асуудал тал талаас ярьж яаж байгаад шийдэж байгаад Байнгын хороон дээр яриад 40-өө гээд 30 болгосон байсан. Тэгээд тал талаас нь дахиж яриад сая дэгээрээ зөвшөөрлөө аваад, хэлэлцэж байгаад, үүнийгээ арай өөрчлөхөөр болгож, бид нар саналаа оруулж хэлэлцүүлэх гэж байна.

Тэгэхээр юуны өмнө хэлэлцүүлж байгаа журмуудынхаа дагуу Байнгын хороо хорооны түрүүчийн хуралдаанаар хэлэлцээд дэмжсэн саналаа хүчингүй болгоод, тэгээд шинэ томъёоллоороо саналаа хураагаад 1 дүгээр асуудлаа шийднэ. Юу яачхав, нөгөө санал хураах томъёолол түрүүчийн хурлаар хураасан томъёолол хаана байна вэ? Байнгын хороогоор хураасан тэрийгээ уншиж танилцуулаад. Санал хураалгах гээд бэлдчихсэн байсан томъёоллоо л өгчих. Бид нар энэний түрүүчийн Байнгын хороогоороо санал хураагаад томъёолсон 10 дугаар санал байгаа. Төслийн 4 дүгээр зүйлийн 30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсэг хэсгийн гэсний дараах 20-иос гэснийг 40-өөс гэж гэснийг 20-иос гэснийг 30-аас гэж өөрчлөх гээд Байнгын хороогоор дэмжчихсэн санал бол байгаа байгаа. Одоо энэийгээ хүчингүй болгоод, дараагийн саналаа томъёолсныгоо танилцуулна. Түрүүчийн саналыг хүчингүй болгох санал хураалт явуулъя. Санал хураалт. 14

гишүүн оролцож 10 хувь дэмжиж, түрүүчийн санал хүчингүй боллоо.

Одоо шинээр хураалгах саналаа танилцуулъя. Та бүхэн саналаа хэлээрэй. Төслийн 4 дүгээр зүйлийн 20-иос гэснийг 40-өөс гэж гэснийг сая бид нар хүчингүй болгочихсон хэсэг шүү дээ. Дахиад уншъя төслийн 4 дүгээр зүйлийн 20-иос гэснийг 40-өөс гэж гэснийг нэр дэвшиж байгаа нийт дэвшигчийн 20-иос доошгүй гэснийг нэр дэвшүүлэхэд 24 оны ээлжит сонгуулиар нийт нэр дэвшигчийн 30-аас доошгүй хувь, 2028 оны ээлжит сонгуулиар 40-өөс доошгүй гэж өөрчлөх. Энийгээ саналаа хураачихъя. Тийм. Асуулт асуулт, асуулт уу, үг үү? Доржханд гишүүний микрофоныг өгье. Доржханд гишүүн.

Т.Доржханд: Нэгэнт ингээд заалтаа өөрчлөх ийм боломжтой болж байгаа бол 2024 оны сонгуулийгаа 35 хувь, 2028 оноо 40 хувь гээд өөрчлөвд явах ийм санал гаргах хүсэлтэй байна. Тэгээд энийг одоо хэлэлцээд шийдвэрлэх боломж байгаа юу гэдэгт хариулт авмаар байна. Баярлалаа.

Н.Энхболд: Ямар ч байсан Байнгын хорооноос томьёолсон саналаараа эхлээд санал хураачихъя. Дэмжигдчихвэл таны саналыг санал хураах хэрэггүй болно гэсэн үг. Дахиад уншлаа шүү. 24 оны нэр дэвшүүлэхэд 24 оны ээлжит сонгуулиар нийт нэр дэвшигчийн 30-аас доошгүй хувь нь, 2028 оны ээлжит сонгуулиар 40-өөс доошгүй гэж өөрчлөхөөр Байнгын хорооноос гаргаж байгаа саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя. Доржханд гишүүнээс бусад нь дэмжиж, 92,9 хувиар санал дэмжигдлээ.

Саяын зөвшөөрөгдсөн дэгээ үргэлжлүүлж ашиглаад би сая танилцуулга дэгийн томьёолол 2 дээр чуулганы нэгдсэн хуралдаан дээр уншсан анхны хэлэлцүүлгээр дэмжигдсэн 53.4 дэх заалтыг өөрчилье гэсэн санал Тогтохсүрэн гишүүн гаргая гэсэн. Тэр саналыг сонсьё.

Д.Тогтохсүрэн: Баярлалаа. Яах вэ бид уржигдар Төрийн байгуулалт биш ээ, ажлын хэсэг хуралдсаны дараа л манайхан яриад л байсан юм. Тэгээд нэгэнт шийдэгдсэн гээд л бид нар явчихсан юм. Тэгээд түрүүний Байнгын хорооны дарга, Байнгын хорооны гишүүд ч гэсэн яриад байна лээ. 53.4 дэх заалт. Тэгээд энэ заалтыг нөгөө жагсаалтаар нэр дэвшигчээс хандив авч болно. Хандивын хэмжээ нь тойрогт нэр дэвшигчдийн хандивын хэмжээнээс хэт дээд хэмжээнээс хэтрэхгүй гэхсэн юм. Тэгээд дээд хэмжээ нь 700 Сонгинохайрхан, Баянзүрх дүүрэг дээр 750 орчим сая төгрөг байдаг юм байна одоо. Сонгуулийн биш ээ, аудитын байгууллага нь тогтоосноор. Тэгэхээр 750-аас буухгүй болчихоод байгаа юм. Тэгэхээр аягүй бүх хүний 750 болгочихно. Энэ аягүй өндөр байна гээд байгаа юм. Тэгэхээр би ийм томьёолол оруулж ирж байгаа юм. Та бүхэн тэгээд саналаа хэлнэ биз.

53.4.Энэ хуулийн 4.3.2-т заасан жагсаалтаар нэр дэвшигч нь нам, эвслийн сонгуулийн сурталчилгаанд зориулан хандив өгч болох бөгөөд нэг нэр дэвшигчийн өгсөн хандивын хэмжээ нь энэ хуульд заасны дагуу тогтоосон нэр дэвшигчээс тойрогт зарцуулах зардлын дундаж хэмжээний 50 хувиас хэтрэхгүй байна. Дундаж гэдэг нь бол 450, 500 орчим сая төгрөг юм байна лээ. Тэгэхээр 250 орчим сая төгрөг болно л гэдэг л дундаж нь нэг ийм болж байна. Нэг ийм зүйл хэлье. Эсвэл дундаж хэмжээ гэж болно. Эсвэл 50 хувь гэж болно. Баярлалаа.

Н.Энхболд: Та гэхдээ юу шүү дээ. Яг томьёолох саналаа хэлээд тийм, тэгээд дэмжигдэхгүй бол яах юм бэ?

Д.Тогтохсүрэн: Зардлын хэмжээний 50 хувиас хэтрэхгүй байна.

Н.Энхболд: Тэр чинь дэмжигдэхгүй бол бүтнээрээ үлдэнэ шүү дээ. Та тэгэхдээ сүүлд нь хэлэхдээ 2

дахиад аль, аль нь байж болно гээд хэлчихлээ шүү дээ. Тэгэхээр нь нэг талдаа байх хэрэгтэй тийм.

Д.Тогтохсүрэн: Би энэ яг уншсанаа хэлье.

Н.Энхболд: Ойлгосон. Тогтохсүрэн гишүүний, тэгнэ, харин би бас тэгж бодоод байгаа юм, тийм. Тогтохсүрэн гишүүний микрофон өгье.

Д.Тогтохсүрэн: 53.4.Энэ хуулийн 4.3.2-т заасан жагсаалтаар нэр дэвшигч нь нам, эвслийн сонгуулийн сурталчилгааны зориулан хандив өгч болох бөгөөд нэг нэр дэвшигчийн өгсөн хандивын хэмжээ нь энэ хуульд заасны дагуу тогтоосон нэр дэвшигчээс тойрогт зарцуулах зардлын дундаж хэмжээнээс хэтрэхгүй байна гэж л оруулъя тэгвэл. Дундаж хэмжээнээс хэтрэхгүй.

Н.Энхболд: Томьёоллыг ойлгосон уу бүгдээрээ тийм ээ. Санал хурааж болох уу? Санал хураалт. Саяын уншсан томьёоллоор. 2 зүйл уншсан, тийм. Пүрэвдорж асуучих, би хариулчихъя. 13 гишүүнээс, 14 гишүүнээс 13 нь дэмжиж 92,9 хувиар энэ санал дэмжигдэж байна. Санал хураая гэж. Тэгэхээр ингэнэ одоо. Түрүүчийн саналаа хүчингүй болгох ёстой бид нар 2/3-оор. Тийм. Ер нь зарчмын хувьд хэлэлцье гэдгээ хэлэлцлээ. Тийм. Тэгэхээр анхны хэлэлцүүлгээр хэлэлцсэн байсан дээд хэмжээнээс гэсэн заалттай, заалт нь бол энэ бол хуулийн 43.2-т заасан жагсаалтаар нэр дэвшигч нам, эвслийн сонгуулийн сурталчилгаанд зориулан хандив өгч болох бөгөөд нэг нэр дэвшигчийн өгсөн хандивын хэмжээ нь энэ хуульд заасны дагуу тогтоосон нэр дэвшигчээс тойрогт зарцуулах зардлын дээд хэмжээнээс хэтрэхгүй байна гэсэн саналаар дэмжигдчихсэн байсан. Үүнийгээ хүчингүй болгоё, хүчингүй болгохын тулд 2/3-оор хүчингүй болгох ёстой. Эхлээд горимоороо санал хураачих. 2/3-оор санал хураая гэж санал хураалт.

Д.Тогтохсүрэн: Нөгөө санал хураагаад байна гээд л дуудаад байна.

Н.Энхболд: Одоохон дуусна. Тийм. 14 гишүүн оролцож бүгдээрээ горимын саналыг дэмжлээ.

Тэгвэл саяын Тогтохсүрэн даргын санал болгосон томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 100 хувийн саналаар дэмжигдлээ. Саяын Дэгийн тухай танилцуулаад чуулганы нэгдсэн хуралдаанаас өгсөн баталсан баталж өгсөн Дэгийн дагуу 2 асуудлаа хэлэлцэж дууслаа. Би хэлэх гэж байна, хэлэх гэж байна. Та яасан яаруу юм бэ дээ. Пүрэвдорж гишүүн бас нэг санал гаргая гээд байгаа юм.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр энэ Сонгуулийн сонгуулийн тухай хуульд Их Хурлын сонгуулийн тухай хуульд урьд нь байгаагүй нэг заалт бас энэ, дахиад юугаа шинээр авчихъя дарга, дарга шинээр авчихъя.

Н.Энхболд: Пүрэвдорж гишүүний цагийг шинээр нь өгчихье.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд шинээр нэг заалт оруулж ирсэн. Өөрөөр хэлбэл тойрогт нэр дэвшүүлж байгаа нам заавал 39-өөс доошгүй нэр дэвшигчтэй байна гэсэн ийм заалт байгаа. 50 хувиас доошгүй гэж. Тэгэхээр энэ би одоо энэ дээр энэ СБД-ийн 2020 оны саналын хуудсыг хараад сууж байна. Энэ дээр бол тухайн үед 2020 онд бол нийтдээ 29 намтай байсан. 29 нам намаас зарим нь эвсэл болоод нийтдээ 17 субъект энэ 20 оны сонгуульд оролцсон байгаа юм. Тэгээд энэ 20 оны сонгуульд оролцохдоо жишээ нь яг энэ СБД дээр бол 13 субъект юунд намууд оролцсон байна. Эвсэл болоод ингээд оролцсон. Тэгэхээр энэ заалт хэрвээ ингээд 39-өөс доошгүй гэдэг заалт байх юм бол энэ сонгуульд одоо жишээ нь өнөөдөр 39 намтай болчихсон, 37 намтай болчихсон байгаа. Тэгэхээр ирэх сонгуульд бол 22-оос, 21-ээс 22 субъект оролцоно гэж би тооцож байгаа. Энэ тохиолдолд

бол СБД дээр зайлишгүй 2 хүнийг аль нэг нь тэр нам дэвшүүлэхээс өөр аргагүй болно. Тэгэхээр энэ саналын хуудас чинь 3 ширхэг хуудас болох юм байна. Өөрөөр хэлбэл энэ дугуйлж байгаа энэ тэр нөгөө нэг тэр чинь тусгай программтай, тогтчихсон юу ийм хуудасны юутай шүү дээ. Тэгэхээр ингэхээр 3 хуудас саналын хуудастай болох юм байна. Унишуулж байж, тэгээд явах юм байна. Тэгэхээр энэ ийм асуудал гаргаад байна.

Дээрээс нь юу байдаг юм жишээ нь тойрогт нэр дэвшиж байгаа дэвшилээ гэхэд урьд нь бол жишээ нь Увс аймагт 23 нэр дэвшигч байсан бол тийм ээ, 24 оны сонгуулиар 45, 6 сонгогчид нэр дэвшигч гарч ирэх юм байна. Тэгэхээр энэ тохиолдолд бол нөгөө саналын хуудас чинь 3 ширхэг болох юм байна. Тэрнийгээ яаж унишуулах юм энэ тэр гээд зөндөө асуудлууд гарна. Тийм учраас энэ 39-өөр заавал ингэж нэр дэвшихийг ингэж тулгах нь бол буруу гэж үзэж байгаа. Тийм учраас энэ ямар ч байсан энэ дээр хэрвээ горимын санал гаргах юм бол саяын Дэгийн тухай хуулиар ямар боломж байна вэ? Энэ дээр тодорхой санал гаргаад, энэ 39-ийг зайлишгүй 39 биш, өөрсдийнхөө жишээ нь үндэсний хэмжээнд бүтэцгүй намууд байж байна. Тэр намуудын намууд бол жишээ нь Дорнод аймагт ч юм уу аль эсвэл Говь-Алтай аймагт ч юм уу дэвшүүлэхгүй байх тийм боломжтой байхгүй юу даа. Өөрийнхөө хүсэж байгаа тэр тойрогтоо, тойрогтоо нэгхэн хүн дэвшүүлээд явсан ч болно. Аль эсвэл бүтэн дэвшүүлэх ч боломжтой. Тэгэхээр ингэж нэг тоогоор хязгаарлаж өгөх нь хүний эрхийг хязгаарласан ийм үйлдэл болж байна гэж үзэж байгаа.

Тийм учраас энэ дээр зарчмын зөрүүтэй санал гаргамаар байна. Хэрвээ зарчмын зөрүүтэй санал гаргах юм бол саяын дэгийн өөрчлөлттэй нийцэх үү гэдгийг Байнгын хорооны даргаас асууя. Протокол тэмдэглүүлж байгаа.

Н.Энхболд: Ойлголоо. 1 дүгээрт 29, 2019 онд Үндсэн хуульд оруулсан

нэмэлт, өөрчлөлтөөр намууд бол бодлого боловсруулдаг, улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулах хэмжээний чадавхтай, боломжтой нөөцтэй байх ёстой гэдэг шаардлагыг оруулчихсан байж байгаа. Энэ шаардлага, энэ зарчмыг гишүүд ойлгож дэмжиж тийм байх нь зүйтэй гэж үзсэн байх гэж бодож байна. Яагаад гэвэл өргөн барьсан хуульд заасан тэр доор хаяж нэг төдий хэмжээний тойрогт нь нэр дэвшиүүлж байж, улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулах нам байх ёстой шүү дээ гэж ойлголтоор саналаа өгсөн болов уу гэж ойлгож байгаа. Тэгээд энэ удаа дараагийн хэлэлцүүлгүүдээр хэлэлцэгдээд дэмжигдээд явчихсан байгаа.

3 дугаарт сая би Байнгын хороон дээр хэдүүлээ хуралдаад, Их Хурлаас чуулганы хуралдааны дэгээр зохицуулаагүй асуудлыг хэлэлцэх дэгээр батлуулж авахдаа 1 дүгээрт төслийн томъёолж оруулаад Их Хуралд санал хураалгах гээд байж байсан төслийн 10 дахь зарчмын зөрүүтэй санал, 2 дугаарт 53.4 дэх анхны хэлэлцүүлгээр дэмжигдсэн байсан санал 2-ыг л дахин хэлэлцүүлнэ гэдэг зөвшөөрлийг энэ дэгээр авсан учраас яг одоогийн байдлаар бол бид нар саяын таны саяын хэлсэн асуудлыг хэлэлцэх боломж байхгүй байна. Батсуурь гишүүн. Батсуурь гишүүнийх.

Ж.Батсуурь: Саяын нөхцөл байдлаас харахад ийм байгаа байхгүй юу. Нам 39 хүртэл гэж байна. Тэгвэл эвсэл яах юм бэ? Жишээлбэл босгыг нь болонгуут 2 тусад нь тавьж өгчхөөд, нам болонгуут 4 хувь, эвсэл, 2 эвсэл бол төд, 3 эвсэл бол төд гэхээд, тэгсэн мөртөө нэр дэвших эвслийг нь 39 гэхээр чинь энэ 2 чинь яг 2 өөр зарчим үйлчлээд эхэлчээж байгаа байхгүй юу. Тийм учраас энийг бол Пүрэвдорж гишүүний хэлдгээр засахаас өөр арга байхгүй шүү дээ. Тийм байгаа биз дээ? Үгүй ээ, тэгэхдээ энэ чинь өөрөө хоорондоо зөрчилтэй заалт байна шүү дээ.

Жишээлбэл нам 4 хувийн босго, 2 эвсэл бол 5 болов уу, 3 бол 7 гэсэн ингэж

зааж өгчхөөд, нэр дэвших асуудлыг нь болонгуут нь бүгдийг нь ижил нам, 1 эвсэл, 2 эвсэл, 3 эвсэл бүгд 39 хүртэл гээд зааж өгнө гэдэг чинь өөрөө зарчмын хувьд таарахгүй асуудал шүү дээ. Тийм.

Н.Энхболд: Эвсэл бол нэг нам болоод л орж байна гэсэн үг шүү дээ ер нь бол. Нэг субъект болоод л орж байгаа шүү дээ Батсуурь гишүүнээ. Миний ойлгож байгаагаар. Тэгвэл би ерөөсөө хариулахаа больё. Таны наадах чинь протоколд л хүрдэг. Одоо бид нарын Байнгын хороогоор ярих асуудал биш байна. Үгүй ээ, яг ярьж байгаад л бүгдээрээ дэгээрээ л хийцгээсэн шүү дээ. Бүгдээрээ баталчихсан. Дуртай, дургүйн тухай асуудал энд ерөөсөө байхгүй. Байнгын хороогоор, Мөнх-Оргил гишүүн.

Ц.Мөнх-Оргил: Баярлалаа. Дэгээр хэлэлцэж болохгүй юм бол энэ протоколд тусгачихъя даа. Энэ Пүрэвдорж гишүүний саналыг уул нь хүлээж авах л ёстой л юм байна л даа. Яагаад гэвэл улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулах шаардлага сонгуульд нэр дэвшүүлэх тоо хоёрын хооронд бол шууд харилцаа холбоо байхгүй л дээ. 2 хүн ч байна уу, 1 хүн ч гэсэн дэвшүүлээд тэр хүнээрээ дамжуулаад улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байна уу, үгүй юү гэдэг бол бас л үзэмжийн л асуудал. Тэрнээс яг төдөн хүн дэвшүүлчхээд улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулах шаардлага нь энэ юм гэхэд тэгэхээр буруу л тийшээгээ яваад байх санагдаад байх юм. Тэгээд наадах чинь бол Цэц дээр очоод, Цэцийн босгыг давахгүй л болов уу гэж би бодоод байгаа юм. Протокол дээр тэмдэглүүлчихье. Би Пүрэвдоржийн саналыг дэмжиж байна.

Н.Энхболд: Саналаа протоколд тэмдэглэж үлдээлээ. Байнгын хорооны хуралдаан дууслаа. Гишүүддээ баярлалаа.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

БУУЛГАЖ, ХЯНАСАН:

ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

